

**Уул уурхайн олборлолтын төслийн байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас**

Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: Нагааранз ХХК

Төслийн байршил: Улаан чулуут

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020444

Огноо: 2023.09.30

#	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо							Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
		Г1	Г2	Г3	Г4	Г5	Г6	Г7		
	1	2	3	4	5	6	7	8	10	11
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	18	19	17	18	18	19		18.16666667	
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	26	27	29	27	27	27		27.16666667	
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	9	9	9	9	9	8		8.833333333	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	5	4	4	4	4	5		4.333333333	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	5	5	4	4	5		4.666666667	
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	9	9	9	9	9	9		9	
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5		5	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	4	4	5	5	5		4.666666667	
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	4		4.833333333	
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	4	3	3	3	3	4		3.333333333	
	Нийт оноо	91	90	90	89	89	91		90	

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" А/618 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/487 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээр 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь үзэхэд 90 % үнэлэгдсэн.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд доорх асуудлуудыг тусгах шаардлагатай

Нөхөн сэргээлтийн чиглэлээр

- Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д заасны дагуу өөрийн эзэмшлийн газрын 10 хувиас доошгүй талбайд мод тарьж, зүлэгжүүлэх
- Үржил шимт хөрсний овоолгод ялзмаг, механик бүрэлдэхүүн, давсны агууламж, хөдөлгөөнт элементийн шинжилгээг хагас жил бүр тутам хийх.
- Эрүүл газарт хөрс суулгах, овоолго байгуулах байгуулах бүрд талбайн үржил шимтэй хөрсийг хуулан шимт хөрсний овоолгонд хадгалах. Нөхөн сэргээх үйл ажиллагаанд эргүүлж ашиглах зорилгоор овоолго үүсгэж, механик өгөршлөөс хамгаалах
- Шимт хөрсний чанарыг алдагдуулахгүй салхи, үер усны нөлөөгөөр хорогдож багасгах мөн тоосжилт үүсэх нөхцөлөөс урьдчилан сэргийлж, олон наст ургамлыг үрээр ургамжлуулан хадгалах арга хэмжээ авах.

Биологийн олон янз байдал, дүйцүүлэх хамгаалах чиглэлээр :

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Чиглэл хүргүүлэх тухай” 2020 оны 12-р сарын 22-ны 01/8786 тоот албан бичигт заасны дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд нь 2023 онд Мөнххаан сумын Бүрэнцогт багийн нутаг дах хөх өндөр нэртэй х.ө 46 44' 10.36", 111 41' 52.55" солбилцолд орших эвдрэлд өртсөн талбайгаас 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийлгэх санал өгч байна.
- Тус сумын 1-х багийн нутаг дэвсгэрт байрлах монгол тарвагын нутагшил өсөлт үржилд, хамгаалалтад сум орон нутагтай хамтран ажиллах.

Хог хаягдлын чиглэлээр :

- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинэн материал / дугуй, сав баглаа боодол / зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулах, сумын Засаг даргын заасан цэгт хог хаягдлын цэг байгуула.
- Машин техникийн засвар үйлчилгээнээс гарсан удаан задардаг органик бохирдуулагчийг зохих журмын дагуу БОАЖЯ-аас зөвшөөрөл авсан мэргэжлийн компанид тушаах.
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд ус, агаар, хөрсөнд шинжилгээ хийлгэн сөрөг нөлөөллийг бууруулан ажилах.
- Тусгай зөвшөөрлийн талбайн бүрэн бүтэн байдал, бохирдол доройтлыг хариуцах.

Авто замын чиглэлээр:

- Дотоод тээврийн авто замыг тоосжилтоос сэргийлж усалж байх

- Гадаад тээврийн авто замын чиглэл болон трассыг холбогдох газраар батлуулж, Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолын дагуу тусгай зориулалтын авто зам барьж ашиглах асуудлыг Олгой булаг, Премиум көүл ХХК-уудтай хамтран шийдвэрлэх.
- Тусгай зориулалтын авто зам барьж ашиглалтанд оруулахаас өмнө нүүрс экспортлох үйл ажиллагаа явуулахгүй байх.

Усны чиглэлээр:

- Ахуйн хэрэгцээнд ашиглаж буй ус, зам талбайн зориулалтаар ашиглаж буй усыг ТЭЗҮ, БОНБНҮ-нд тусгагдсаны дагуу холбогдох газраар дүгнэлт гаргуулж, шугам бүрийг тоолууржуулах.
- Усны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т заасан зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласны усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцон төлөхөөр заасныг анхаарч, жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, графикийг үнэн зөв гаргаж байх.
- Шавхан зайлуулж буй усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж Баянголд нийлүүлэх ажлыг Олгой булаг, Премиум көүл ХХК-уудтай хамтран зураг төсвийн дагуу байгуулах.
- Усны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-т заасан зохих зөвшөөрлийн дагуу иргэн аж ахуй нэгж байгууллагын өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан, сэргээн засварласан усны барилга байгууламж нь тэдгээрийн өмчлөлд байж болох бөгөөд харин усны нөөц нь нийтийн ашиглалтанд байх.
- Уурхайн ажилчдын унд ахуйн худгийн усны шинжилгээний дүгнэлтээс хамааран стандартын дагуу цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах.
- Усны тухай хуулийн 17.1.8-д сав газрын захиргаа нь "Сав газрын хэмжээнд ус хангамжийн эх үүсвэрийн болон хаягдал ус зайлуулах цэг тогтоох", 30.1.3-т хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах,
- Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 156 дугаар тушаалаар батлагдсан "Ус ашиглах, хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хэмжил зүйн төв байгууллагаас эрх авсан мэргэжлийн байгууллагаар ус авах цэг, цооног, худаг, ус дамжуулах шугамын оролт бүрт баталгаажуулсан тоолуурыг суурилуулах, тоолуурын заалтыг үндэслэн усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх;
- Газрын доорх болон гадаргын усны тэнцвэр алдагдсанаас хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх бохирдлын явц, нөлөөллийг судлаж цаашид үзүүлэх нөлөөллийг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутагт тарих модны тооцоо судалгааг хийж Засгийн газрын 179 дүгээр тогтоолын дагуу байгаль орчныг хамгаалах, уурхайн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, нийгийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээнд тусган хэрэгжүүлэх.
- Нүүлгэн шилжүүлэх нөхөн оловор олгох арга хэмжээний биелэлтийг сум орон нутаг нөлөөллийн бүс дэх иргэдтэй тохиролцсоны дагуу хэрэгжилтийг ханган ажиллах.
- 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулахаар өгсөн ажлуудыг хэрэгжүүлэх.

- Байгаль орчны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.7 - т заасны дагуу байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн томилон ажиллуулах.
- Явуулж байгаа үйл ажиллагааны талаар сонирхогч талууд болох багийн иргэдэд танилцуулга мэдээлэл хүргэж, олон нийтийн саналыг авах.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, БОХ-3 тайланг хугацаанд нь үнэн зөв гаргахад анхаарч ажиллах шаардлагатай.
- БОМТ-ны тайлагналтанд анхаарч, хариуцлагатай тайлагнах. Эрх бүхий албан тушаалтанг байлцуулах.

ТЭЗҮ, БОНБНУ-нд тусгагдсан бусад асуудлыг анхааралдаа авч уулын ажлын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

Ажлын хэсгийн дарга:

БОАЖГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.Нямхүү

Гишүүд:

МХГ-ын байгаль орчны хяналтын

Улсын байцаагч

Н. Дэлгэрмандах

Н.Дэлгэрмандах

Сав газрын захиргааны төлөөлөгч

Э.Болорчимэг

Сүхбаатар сумын БОХУВ

С.Ганбулган

Сүхбаатар сумын иргэдийн төлөөлөл

Цогбаяр

Хүлээн зөвшөөрсөн:

Нагааранз ХХК-ны гүйцэтгэх захирал

Д.Мягмардорж





**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “НАГААРАНЗ” ХХК-ИЙ
MV-020444 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “ТӨХӨМ”-ИЙН ХҮРЭН
НҮҮРСНИЙ ОРДЫН ЗҮҮН ХЭСГИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2022 он

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ
MV-020444 тоот АШИГЛАЛТЫН тусгай зөвшөөрөлтэй
“НАГААРАНЗ” ХХК- ний
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-020444/

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 9011048078 /

ХЯНАСАН:

БОНХЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Ц.ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН :

НАГААРАНЗ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д. МЯГМАРДОРЖ

НАГААРАНЗ ХХК-ИЙН ХАБ-ЫН БАЙГАЛЬ ОРЧИН
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Н. МӨНХ- ЭРДЭНЭ

2022 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
1.1. Ордын газарзүйн байршил.....	6
1.2. Төслийн түүхэн товчоо	6
1.3. Байгаль орчны төлөв байдал.....	7
1.3.1. Ландшафт, газрын гадаргын онцлог	7
1.3.2. Уур амьсгал, агаарын чанар	7
1.3.3. Усан орчин.....	7
1.3.4. Хөрсөн бүрхэвч.....	7
1.3.5. Ургамлан нөмрөг	7
1.3.6. Амьтны аймаг.	8
1.4. Ордын нөөцийн тооцоо.....	8
1.5. Уурхайн хүчин чадал, ажиллах горим.....	9
1.5.1. Хүчин чадал	9
1.5.2. Уурхайн ажиллах горим.....	9
1.6. Ил уурхайн ашиглалтын систем болон үндсэн параметрууд	10
1.7. Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмж.....	10
1.8. Ил уурхайн туслах тоног төхөөрөмж	11
2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	11
2.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	11
2.2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	12
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО	13
4. НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	14
4.1. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ.....	Error! Bookmark not defined.
4.2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	15
4.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	17
4.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	18
4.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	20
4.6. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа.....	21
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-020444 Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбилцол.....	6
Хүснэгт 2. Ордын геологийн нөөцийн нэгдсэн хүснэгт	8
Хүснэгт 3. Ашиглалтын үеийн нөөц	9
Хүснэгт 4. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө.....	9
Хүснэгт 5. Уурхайн ажиллах горим, хугацаа.....	10
Хүснэгт 6. Ашиглалтын системийн үндсэн параметрууд.....	10
Хүснэгт 7. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх	11
Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл.....	13
Хүснэгт 9. Агаарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
Хүснэгт 10. Хөрсөн бүрхэвчинд нөлөөллийг бууруулах.....	15
Хүснэгт 11. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	17
Хүснэгт 12. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	18
Хүснэгт 13. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	20
Хүснэгт 14. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа	21
Хүснэгт 15. 2022онд нөхөн гүйцэтгэх дүүцүүлэн хамгаалах арга хэмжээ түүний өргөрөгийн байршил. 24	

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

1. Төсөл хэрэгжүүлэгч компаний улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Төсөл хэрэгжүүлэгч компаний ашиглалтын тусгай зөвшөөрөл
3. Техник-Эдийн засгийн үндэслэлийн тушаал
4. Техник-Эдийн засгийн үндэслэлийн дүгнэлт
5. Байгаль орчны лавлагаа
6. Уул уурхайн кадастрын зураг

“УЛААНЧУЛУУТ УУРХАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ”

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	Нагааранз ХХК
	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011048078
	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Уул уурхай
	Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	/Хануул дүүрэг 18 хороо, Оргил стадион, UNIT CENTER 403тоот/
	Захиралын нэр	Ц. Энхтайван
	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Гүйцэтгэх захирал Д.Мягмардорж Утас:88113061
1.2	Төслийн нэр	Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төхөм зүүн хэсгийн Улаанчулуут хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах
	Төслийн харъялалын байршил	Төхөмийн зүүн хэсгийн Улаанчулуут талбай нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумаас зүүн урагш 38 км зайд байрладаг
	Төслийн ангилал	Нүүрс
	Төсөл эхэлсэн огноо	2018 он 06 сар 20 өдөр
	Төсөл хэрэгжих хугацаа	15 жил
	Уурхайн хаалт эхлэх огноо	2033 он
	Хаалтын дараах зориулалт	Бэлчээрийн зориулалтаар
	ТЭЗҮ баталсан огноо	2018 он
	Урьд оны нийт бүтээгдэхүүний хэмжээ /дундаж/	2021 онд covid19 цар тахал болж ажиллаагүй
	Ажилчдын тоо	16
	Тухайн жилийн нийт гүйцэтгэсэн ажил	137мян.м ³ хөрс хуулсан Нүүрс олборлоогүй
	Тухайн жилийн нийт борлуулалтын хэмжээ	2022 онд covid19 цар тахалын улмаас экспорт хийгдээгүй болно.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Ордын газарзүйн байршил

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт орших **MV-020444** тоот тусгай зөвшөөрөл бүхий Төхөм хүрэн нүүрсний ордын зүүн, зүүн урд, урд жигүүрийн Улаанчулуутын талбай нь Сүхбаатар сумаас зүүн урагш 38 км зайд байрладаг.



Зураг 1. Улаанчулуут уурхайн байршил

Хүснэгт 1. MV-020444 Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбилцол

Д/д	Уртраг			Өргөрөг		
	Град	мин	сек	град	мин	сек
1	114	17	30.00	46	34	12.31
2	114	16	27.48	46	33	1.76
3	114	15	32.39	46	33	1.76
4	114	15	32.39	46	35	1.77
5	114	17	30.00	46	35	1.77

1.2. Төслийн түүхэн товчоо

“Нагааранз” ХХК нь 2006 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд үүсгэн байгуулагдсан цагаас гадаад худалдаа, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн байна. 2008 онд Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах Төхөмийн хүрэн нүүрсний ордын зүүн жигүүрийн Улаанчулуут ордын **13150X** тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг Ашигт Малтмал Газрын тосны хэрэг эрхлэх газраас зохих журмын дагуу хүлээн авч үйл ажиллагаагаа эхэлсэн болно. Тасралтгүй хагуул хийсний үр дүнд 2015 онд Монгол Улсын Эрдэс Баялгийн Мэргэжлийн зөвлөлөөр тайланг баталгаажуулан Улсын нэгдсэн нөөцийн мэдээллийн санд бүртгүүлэн МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газрын даргын 2015 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн **H/28** тоот Нөөцөд бүртгэх тухай тушаал гарсан билээ. Улмаар дээрх тушаал шийдвэрийн дагуу 2016 оны 1-р сарын 21-ний өдөр тус компанид **MV-020444** тоот дугаар бүхий **783,36 га** газрыг ашиглалтын тусгай

зөвшөөрөл олгосон юм.

Улаанчулуут уурхай нь 2018 онд Эрдэс баялгийн үндэсний зөвлөлөөс баталсан ТЭЗҮ-ийн тодотголын дагуу жилд **500,000 тонн** нүүрс олборлох хүчин чадалтайгаар 2018 оны 06 сарын 20-ны өдрөөс эхлүүлсэн ба одоогоор худалдан борлуулах нүүрсний овоолго хийгдэж байна.

1.3. Байгаль орчны төлөв байдал

1.3.1. Ландшафт, газрын гадаргын онцлог

“Улаан чулуут” хүрэн нүүрсний орд нь Акад. Ш.Цэгмид (1964)-ийн боловсруулсан физик газарзүйн мужлалаар Дорнод Монголын их мужийн Баруун –Уртын тойрогт багтана. Газрын гадаргын хэлбэр дүрсийн хувьд тэгширмэл газар, уулс хоорондын хотос зонхилсон элэгдлийн гаралтай тэгш тал болон харьцангуй нам өндөртэй, ухаа гүвээт долгиот тал зонхилно. Уул хоорондын хотос болон ул чулуулаг дээрхи элэгдлийн суурьт тал дээр үүссэн тэгширмэл гадарга ялимгүй сэргэж хэлбэршсэн үлдмэл дундаж өндөр ба нам уулс бүхий гадарга зонхилно. Төслийн талбай орчимд Төмөртийн овоо **1139.4 м** уул байрлана.

1.3.2. Уур амьсгал, агаарын чанар

Судалгааны талбай нь цаг уурын мужлалтын хувьд Монголын тэгш өндөрлөгийн адилаар эх газрын эрс тэрс уур амьсгалын хэв шинж зонхилно. Орон нутгийн уур амьсгалын хувьд чийглэгдүү хүйтэн зунтай, хахирдуу өвөлтэй бүсэд багтдаг бөгөөд зонхилох агаарын массын хувьд Номхон далайн Муссон нөлөөлөх боломжтой гэж үздэг. Баруун -Урт сумын цаг уурын олон жилийн хэмжилтийн дүнгээс харахад жилийн дундаж агаарын температур нь **-2°C** байдаг. 1-р сарын агаарын температур **-25°C**, 7-р сарын агаарын температур **+20°C** байдаг. **+10°C**- аас дээш температуртай өдөр жилд дундажаар 130 орчим, дулааны нөөц **2400°C** хүрнэ.

Жилд дундажаар **220мм** хур тунадас хүлээн авах бөгөөд үүний **60%** нь зун буюу 4-р сараас 10-р сарын хооронд унадаг. Тогтвортой цасан бүрхүүл 11-р сарын дунд үеэс эхлэн тогтох бөгөөд 3-р сарын 20-ноос эхлэн хайлна.

Аймгийн нийт нутаг дэвсгэрээр “Баруун-хойт” зүгийн салхи зонхилж ажиглагддаг. Салхины сарын дундаж хурд **5-10м/с**. Салхины хурд нь зун ба өвөлдөө багасан, хавар намартаа нэмэгдэж, хамгийн их хурд секундэд **12-40** метр хүртэл ширүүсдэг.

1.3.3. Усан орчин

Тус бүс нутаг нь гидрогеологийн мужлалаар Номхон далайн ай савын улирлын дунд зэргийн тэжээлтэй, Монголын Дорнод хэсгийн дэд мужид харъяалагдах бөгөөд усзүйн хувьд түр зуурын болон байнгийн урсгалтай гол, тогтоол нуур байхгүй. Зуны улиралд хур тунадасны усаар тэжээгдэх тогтоол нуурууд үүснэ.

1.3.4. Хөрсөн бүрхэвч

Судалгаанд хамрагдсан бүс нутаг нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар төв Азийн хөрс-био уур амьсгалын их мужийн Хангай мужийн холимог бүсшилийн хэв шинж бүхий Монголын дорнод хэсгийн 19-р тойрогт харъяалагдана. Энэ тойрогт ухаа гүвээт тал болон уул хоорондын нам хотос хөндий зонхилох бөгөөд үетэнт, агь-үетэнт, алаг өвс-үетэнт хуурай хээрийн ургамалшил бүхий ургамалшилтай. Судалгааны бүс нутагт хар хүрэн, хүрэн шороон хөрс голчлон тархах бөгөөд гадаргын хэлбэр дүрс, ургамлын тархалттай уялдан зонхилон тархах хөрсний хэв шинжийн хувьд ухаа гүвээт толгод бүхий нутгаар хүрэн хөрс-сайр чулуурхаг нимгэн ялзмагт давхаргатай хүрэн хөрс тархах бол ухаа гүвээт бүхий долгиот талаар зузаан ялзмагт давхаргатай, үе давхарга тод ялгаран хөгжсөн хар хүрэн хөрс зонхилох уул хоорондын хөндий, нам дор хотом газруудаар нугархаг хар хүрэн хөрс тус тус зонхилон тархана.

1.3.5. Ургамлан нөмрөг

Ургамал–газарзүйн мужлалтаар Евроазийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн чийглэгдүү хэв

шинжийн Дорнод Азийн тойргийн Дэгээ-Нөмрөгийн тойрогт багтана. Судалгааны талбайд голлох ухаа гүвээт талаар *Carex pediformes* болон *Galium verium* зонхилсон алаг өвс-үетэнт, үетэнт-шарилжит, агь-хялганат бүлгэмдэл голлосон хуурай хээрийн ургамалшлын хэв шинж зонхилно.

1.3.6. Амьтны аймаг

Дорнод бүсийн нийтлэг амьтад бол цагаан зээр, тарвага, үнэг, чоно, мануул, туулай, өмхий хүрнэ, хярс юм. Энэ бүс нутгаас Сүхбаатар аймгаас 8 зүйлийн агнуурын амьтан агнаж улсын бэлтгэлд тушааж байсан мэдээ бий.

Хамгийн дэлгэр оршдог туурайтан хөхтөн бол цагаан зээр бөгөөд тухайн бүс нутгийн экосистемийн анхдагч түлхүүр зүйл болно.

Цагаан зээр болон бусад хөхтөн хоол тэжээлийнхээ байдлаас болж нүүдлийн байдалтайгаар амьдралынхаа үйл ажиллагааг явуулж биологийн бусад төрөл зүйлтэй харилцан нөлөөлөлцөж байдгаа илэрхийлдэг байна. Жижиг араатан амьтнаас хотны үен элбэг бөгөөд үлийн цагаан оготноор голчлон хооллодог учир энэ бүс нутагт элбэг байгаа юм. Мөн Дагуур огодой тал хээрийн экосистемийн холбоонд гол байр суурь эзлэн, эндхийн жижиг махан идэштэн, махчин шувуудын үндсэн хоол тэжээл болдог байна. Үлийн цагаан оготоно, дагуур огодой, зурам зэргийг дагаж хярс, цагаан зээрийг дагаж чоно элбэг үзэгдэнэ.

1.4. Ордын нөөцийн тооцоо

Ордын нөөцийн тооцоог хийхдээ "Ашигт малтмалын нөөц баялагийн ангилалын түр заавар" заавруудыг ашигласан байна. Эдгээр заавруудыг үндэслэн уг ордын ашиглах хэсгийг геологийн тогтоцын хувьд II бүлэгт, нүүрсний давхраас нь энгийн тогтоцтой, зузаан нь харьцангуй тогтвортой бүлэгт тус тус хамааруулсан байна.

Нөөцийн тооцоонд орох нүүрсний давхраасны огтлол (цооног) бүрийн бүтцийн болон чанарын үзүүлэлтийн баганыг 1:50 масштабтай хийж эндээс жишгийн үзүүлэлтийн шаардлага хангасан үеүдийг ялган зузаантай нь жигнэсэн дундажийн аргаар бохирдсон (чулууны үеийг оролцуулсан) үнслэгийг тооцсон байна.

Хэсэгчлэлийн талбайг судлагдсан торны нягтралд тулгуурлан түүнийг нөөцийн тооцооны хэсэгчлэл, нөөцийн үнэмшлийн зэрэгт (категори) хувааж тооцоолсон байна.

Нөөцийн тооцооны хэсэгчлэлүүдийн талбайг AutoCAD программ ашиглан тодорхойлсон ба нөөцийн тооцооны хэсэгчлэл бүрийн нүүрсний давхраасны дундаж зузаан болон, үнслэгийг жигнэсэн дундажийн аргаар тооцоолсон байна.

Хүснэгт 2. Ордын геологийн нөөцийн нэгдсэн хүснэгт

Блокын дугаар нөөцийн зэрэг	Блокын талбай м ²	Нүүрсний зузаан				Эзэлхүүний жин гр/см ³	Нөөц /тонн/		
		Өгөршсөн нүүрсний	Цэвэр нүүрсний	Чулууны үетэй	Өгөршсөн нүүрсний		Цэвэр нүүрсний	Чулууны үетэй нүүрсний	
1A	301,581.4	4.5	40.1	42.6	1.37	1,859,249.3	16,567,977.3	17,600,870.3	
2A	92,397.9	4.8	29.0	30.0	1.37	607,608.6	3,670,968.5	3,797,553.6	
4A	81,285.8	3.6	21.3	21.5	1.37	402,906.1	2,383,861.9	2,406,245.6	
3B	77,303.9	6.5	19.4	19.8	1.37	694,586.7	2,073,074.3	2,115,818.1	
5B	126,795.0	3.6	34.7	37.8	1.37	629,730.4	6,069,901.4	6,612,169.3	
6B	126,119.4	2.7	11.2	14.1	1.37	466,515.5	193,5176.6	2,436,248.4	
8B	84,062.6		5.3	5.7	1.37		610,378.5	656,444.8	
9B	105,729.1	4.9	22.4	22.4	1.37	709,759.4	3,244,614.6	3,244,614.6	
12B	112,068.3	3.2	53.5	55.6	1.37	498,677.0	8,337,256.7	8,664,513.5	
7C	160,559.5		12.5	13.6	1.37		2,749,581.4	2,991,544.6	
10C	119,336.0	6.3	12.4	12.9	1.37	1,042,348.9	2,051,607.3	2,134,333.4	

11C	135,025.3	2.7	11.3	14.5	1.37	505,452.0	2,115,410.5	2,714,464.9
13C	180,348.6		9.0	9.8	1.37		2,257,053.7	2,457,680.7
14C	175,283.7	1.3	11.7	15.2	1.37	312,180.2	2,050,819.3	2,809,622.4
A						2,869,764.0	22,622,807.7	23,804,669.5
B						2,999,269.0	22,270,402.1	23,729,808.7
C						1,859,981.1	11,224,472.2	13,107,646.0
Нийт						7,729,014.1	56,117,682.0	6,064,2124.2
Баруун урд жигүүрт								
15C	230,517.00			20.70				6,635,290.00
16P ₁	427,490.50			21.70				12,899,498.00
Нийт								80,176,912.20

Хүснэгт 3. Ашиглалтын үеийн нөөц

Уурхайн хил хязгаар доторхи геологийн нөөц, мян.тн	Бохирдол		Хаягдал		Үйлдвэрлэлийн нөөц
	мян.тн	%	мян.тн	%	мян.тн
48,762.13	228.305	0.47	1,053.88	2.2	47,936.55

Үйлдвэрлэлийн үеийн хаягдал бохирдолтыг тооцон уурхайн хөрс хуулалтын коэффициентийг тооцож үзэхэд нийт **84.5 сая.м³** хөрс хуулж, **47.9 сая.тн** нүүрс олборлосон байна. Энэ үеийн хөрс хуулалтын итгэлцүүр мөн **2.0 м³/тн** байна.

1.5. Уурхайн хүчин чадал, ажилласан горим

1.5.1. Хүчин чадал

2022 онд тус ил уурхай нь Covid- 19 цар тахалтай холбоотой хил гааль хаалттай байсан учраас жилийн эхний гурван улирал үйл ажиллагаа бүрэн зогсонги байсан тул хөрс хуулалт болон нүүрс олборлолтын ажил хийгдээгүй. Агуулагч хөрсийг ерөмдлөг тэсэлгээгүйгээр сийрэгжүүлэн экскаватор-автосамосвалын хослолоор ухаж тээвэрлэн гадаад овоолгод байршуулсан байна. 2021 онд **59мян.м³** хөрс хуулж, **6мян.тн** Тухайн жилд 2А блок олборлолтонд өртсөн байна.

Хүснэгт 4. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

Үзүүлэлтүүд	Хөрс хуулалт	Нүүрс олборлолт	Сааж нүүрс	Нийт уулын цул	Хөрс хуулалтын коэффициент	
	м ³	Тн	м ³	м ³	м ³ /тн	
2022	1-р сар	0,0	0,0	0,0	0,0	0,0
	2-р сар	0,0	0,0	0,0	0,0	0,0
	3-р сар	0,0	0,0	0,0	0,0	0,0
	4-р сар	0,0	0,0	0,0	0,0	0,0
	5-р сар	0,0	0,0	0,0	0,0	0,0
	6-р сар	0,0	0,0	0,0	0,0	0,0
	7-р сар	0,0	0,0	0,0	0,0	0,0
	8-р сар	0,0	0,0	0,0	0,0	0,0
	9-р сар	39,978	0,0	0,0	39,978	0,0
	10-р сар	13,868	0,0	48,350	66,794	0,0
	11-р сар	0,0	0,0	30,862	30,862	0.0
	12-р сар	-	-	-	-	-
Нийт	53,846		79,212	137,634		

1.5.2. Уурхайн ажилласан горим

Тус уурхайн баяр ёслолын болон амралтын үед ажилчдын амрах хугацааг МУ-ын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу уурхайн даргын тушаалаар зохицуулна. Уурхай нь жилийн **4** улиралд ажиллах

бөгөөд олборлолт, хөрс хуулалт 1 ээлжийн 10 цагаар хоногт 10 цагаар гүйцэтгэх бөгөөд долоо хоногт ажлын өдөр 7 байхаар тооцож гаргасан боловч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хил гаалийн үйл ажиллагаанаас үүдэлтэй 2022 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан олборлолтын ажил хийгдээгүй. 2022 оны 09 сарын 15 нд олборлолтын үйл ажил эхэлсэн боловч давгдашгүй хүчин зүйлийн улмаас 2022 оны 11 сарын 15 нд МУ- д дизель түлшний хомсдол үүсэн ил уурхайн үйл ажиллагаа түр зогслоо.

Хүснэгт 5. Уурхайн ажилласан горим, хугацаа

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Хуанлийн хоног	хоног	365
2	Засвар үйлчилгээ, цар тахлын үеийн сул зогсолт	хоног	265
3	Уурхайн төлөвлөгөөт ажиллах байсан хоног	хоног	365
4	Ажилласан хоног	хоног	65
5	Хоногт ажиллах цаг	цаг	10
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10

1.6. Ил уурхайн ашиглалтын систем болон үндсэн параметрууд

Уг орд нь ашиглалтын гүн 60-170 метр хүртэл гүн, нүүрс агуулагч чулуулаг нь зөөлөн, том, дунд ширхэгтэй, холимог найрлагатай, сул цементлэгдсэн элсэн чулуу, алевролит, аргиллит, шаварлаг аргиллитын үедээс бүрдэх бөгөөд уурхайн ашиглалтын системийн хувьд жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, уул геологийн болон уул техникийн нөхцөлөөс хамаарч хөрс хуулалт, болон нүүрс олборлох ажлыг шууд ухаж ачихаар экскавалит-автосамосвал-гадаад болон дотоод овоолго гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэдэг.

Хүснэгт 6. Ашиглалтын системийн үндсэн параметрууд

Параметрууд		х.н	Тоон утга	
			Уурхайн карьер #1	Уурхай карьер #2
Өндөр	Уурхайн хамгийн их гүн	м	17	8.5
	Доголын өндөр	м	10	10
	Хөрсний дэд доголын өндөр	м	2.5-5	
	Нүүрсний дэд доголын өндөр	м	3.5-5	
	Овоолгын нийт өндөр	м	16.0	16.0
	Овоолгын доголын өндөр	м	30	
Өргөн	Орлын өргөн	м	35	40
	Аюулгүйн бермийн өргөн	м	5	
	Ажлын талбайн хамгийн бага өргөн	м	30	35
	Замын өргөн	м	20	25
Өнцөг	Ажлын доголын хажуугийн өнцөг	град	55	55
	Ажлын бус доголын хажуугийн өнцөг	град	50	50
	Овоолгын доголын хажуугийн өнцөг	град	35	32
	Замын налуу	%	10	10

1.7. Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмж

Уурхайн ашиглалтын технологийн дагуу гаргасан уулын цулыг тээвэрлэх ажлыг экскаватор-автосамосвалын хослолоор гүйцэтгэж байна. Календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсан хуулах хөрсийг гадаад овоолгод, олборлосон нүүрсийг уурхайн мөргөцгөөс нүүрсний түр агуулах хүртэл тээвэрлэсэн.

Нүүрс, хөрс хуулалтанд Hyundai R520LC маркийн экскаватор 1 ш ажиллаж байна. Нүүрсийг гадаад тээвэрлэлтийн машинуудад нүүрсийг ачих болон хөрсний овоолгонд 3.0 м³ утгуурын багтаамжтай

L953F маркийн 2ш утгуурт ачигч тус тус ажиллаж байна.

1.8. Ил уурхайн туслах тоног төхөөрөмж

Улаанчулуут нүүрсний уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтод ажиллах үндсэн тоног төхөөрөмжөөс гадна уурхайн туслах ажил, зам услах, орчны тоосжилтдарах ажилд Hyundai фирмийн 25 тн усны машин 1 ш, ажиллаж байна.

2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

2.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Орчны бүрэлдэхүүн хэсэг	Сөрөг нөлөөлөл
Агаар орчин	Хөрс хуулах, олборлолтиавуулах, нүүрсийг шигших, тээвэрлэх үед тоосжилт болон дуу чимээ, доргио чичиргээ ихсэх
	Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын түлшний шаталтаас хорт хий ялгарах.
	Сайжруулсан бус зуух, түлшний хэрэглээ, нүүрс болон үнсний талбайгаас тоос үүсэх, тухайн орчны агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх.
	Хог хаягдлын цэг уламжлалт ариун цэврийн байгууламж, бохирын цооногоос орчны агаарт физик бохирдол үүсэх.
Хөрс орчин	Хөрс хуулах, олборлолт явуулах үед хөрсөн бүрхэвч эвдрэх, газрын хэлбэр, төрх өөрчлөгдөж ухаш үүсэх
	Уурхайн барилга байгууламж бүхий газруудын элэгдэл, эвдрэлд өртөх хөрс
	Ил задгай хаясан ахуйн хатуу болон шингэн хог хаягдал, тэсрэх бодисын сав, баглаа боодлын хаягдал, үнс, нүүрсний хаягдал хөрсийг бохирдуулах
	Хүнд даацын болон бусад машин, техникийн засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тос, масло хөрсөнд алдагдсан үед хөрсийг хүнд металаар бохирдуулах
	Шимт хөрсний овоолгын үржил шим алдагдах
	Уламжлалт ариун цэврийн байгууламж болон бохирын цооног хөрс болон хөрсний усыг бохирдуулах
	Тусгайлан бэлдээгүй буюу цементлээгүй талбай дээр хадгалсан буулгасан, хаясан тэсрэх материал, нүүрс, үнс зэрэг хөрсийг бохирдуулах
Гүний ус	Уурхайн ус хэрэглээний улмаас усны нөөц багасаж болзошгүй
	Ил задгай хаясан хог хаягдал, нүүрс, үнс нь хөрсөөр дамжин гүний усыг бохирдуулж болзошгүй
Ургамлан нөмрөг	Хөрс хуулалтаас үүсэх шимт хөрс болон хоосон чулуулгийн овоолгын доорх ургамлан нөмрөг дарагдах
	Уурхайн үйл ажиллагаа, хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас ургамлан нөмрөг устах, тоосонд дарагдах
Амьтны аймаг	Өрөмдлөг, тэсэлгээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг уурхайн үйл ажиллагааны улмаас ан амьтны амьдрах орчин өөрчлөгдөх дайжих

Орчны бүрэлдэхүүн хэсэг	Сөрөг нөлөөлөл
	Зэрлэг ан амьтан уурхайн талбайд орж ирсэн үед зөвшөөрөлгүй хулгайн анд өртөх, ухсан нүхэнд унаж бэртэх нөхцөлтэй
Бусад	Хөдөлмөр хамгаалал болон сургалт мэдээллээр уурхайн ажилчдыг бүрэн хангаагүйн улмаас бэртэж гэмтэх, эсвэл тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг доголдуулж Болзошгүй
	Хүний санамсар, болгоомжгүй үйл ажиллагааны улмаас галын аюул үүсэж улмаар ажилчид болон эд хөрөнгө өртөж болзошгүй
	Хүчтэй салхи шуурга, аянга цахилгаан, газар хөдлөлт, түймэр зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон үед уурхайн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх.

2.2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

- Цахилгааны хэрэглээнд ашиглах дизель станц, авто тээврийн хэрэгсэл зэргийг сонгохдоо шатахуун зарцуулалт багатай, ашигт үйлийн коэффициент өндөртэй технологи сонгох нь төслийн агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, агаар бохирдуулсны төлбөр, агаар орчинд учруулсан хохирлын хэмжээг багасгах зэрэг сайн талтай юм. Мөн орчин үеийн дэвшилтэд, ашигт үйлийн коэффициент өндөртэй технологи нь дуу шуугианы нөлөө багатай байдаг
- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах ялгаралтыг багасгах үүднээс тэдгээр тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал, утааны шүүлтүүр ашиглах, утааны хяналтын хэмжилтийг тогтмол хийлгэж байхаас гадна ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгсэл ашиглахгүй байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
- Талбайн эх үүсвэрээс ялгарах тоос, тоосонцрын агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахдаа энэхүү БОННУ-ний тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг хэрэгжүүлэх
- Агаарын тухай хуулийн 9.1.4-т заасны дагуу энэхүү байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажлын тайлангийн орчны хяналт- шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох, мөн хуулийн 9.1.5-д заасны дагуу Агаарын чанарын мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт дотоод хяналт шалгалтын тухай тайлан, мэдээг гаргаж байх
- Бүс нутгийн биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, байгаль орчны алба, сумын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд тэдгээрт туслалцаа үзүүлэх, санал солилцох;
- Төслийн талбай орчмын өвөлжиж буй нутгийн малчин иргэдийн санал хүсэлтийг харгалзан өөр тийш нүүлгэх, худаг усны асуудлыг шийдэж өгөхөд туслал
- Төслийн үйл ажиллагаа, олборлолтын ажлын үед үүсэх дуу чимээний хэмжээг бага түвшинд байлгах талаар анхаарах шаардлагатай. Тухайлбал, дуу чимээ бага гаргадаг, техникийн үзүүлэлт сайтай тоног төхөөрөмжүүд ашиглах
- Амьтад нэвтрэх боломжтой газар болон нутгийн иргэдийн мал шигүү бэлчдэг, суурьшил ихтэй газруудад замын тусгай анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээг зөв зохистой байрлуулах, Тухайлбал авто замын уртын эхний хагасад орших бэсрэг уул бүхий толгодорхог газруудаар. Жолооч нар зэрлэг ан амьтны нүүдэлтэй тааралдсан тохиолдолд хөдөлгөөнөө зогсоож амьтдыг чөлөөтэй нэвтрүүлэх
- Мөн уурхайн ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрлэг амьтны нүүдэл

шилжилтэд саад болж байгаа эсэхийг байнга шалгах

- Уурхайн үйл ажиллагаа, тээвэрлэлтээс үүдэн гарах тоосжилт амьтны нүүдэл, шилжилт, орогнох газаргүй болгоход хүргэж байгаа учир тоос их гаргадаг тээврийн хэрэгсэлд нэмэлт тоос дарагч төхөөрөмж суурилуулах, аль эсвэл шороон замыг хатуу хучилттай болгох зайлшгүй хэрэгтэй байна
- Шатах тослох материалын талбай сонгох, барьж байгуулах зөвлөмж
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн зөвлөмж

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал юм.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх
- БОННҮ нэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх

Хүснэгт 8. 2022 онд гүйцэтгэх байсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, нэгдсэн зардалын хүснэгт,

№	Ажлын нэр	Зардал /мян. төг/	Хэрэгжсэн эсэх
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	500.0	100%
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-	-
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	4.300.0	2023 онд хийх
4	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	100%
5	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	60%
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	700.0	100%
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5.300.0	100%
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-	100%
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	610.5	100%
Нийт зардал		11,410,5	

2022 онд Цар тахалаас үүдэлтэй Сүхбаатар аймгийн Бичигт боомтын үйл ажиллагаа зогссон байсан тул манай компани нь Боомтын хэвийн ажиллагаанаас шууд хамааралтай тул мөн адил уурхайн олборлолтын ажил зогссон байлаа. МУ- н засгийн газрын шийдвэрээр 2022 оны 7 сарын 22нд Бичигт боомтын ажил эхэлмэгц манай уурхайн үйл ажиллагаа 2022- 09- 15 ны өдрөөс ажилласан боловч 2022- 11- 15 ны өдөр хүртэл 2 сар ажилласан.

Манай улсад түлшний хомосдол үүссэний улмаас ажил түр зогсолт хийсэн. Гэсэн хэдий ч бид дотоод нөөц бололцоогоо ашиглан 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

4. НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


4.1 Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 9. Агаарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал /мян. төг/	Ажлын гүйцэтгэл	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
Орчны тоосжилтыг бууруулах зорилгоор замын усалгааг тогтмол хийх, хурдны хязгаарт хяналт тавих	Уурхайн хэмжээнд технологийн замууд, овоолгын гадарга,	Үйл ажиллагааны зардалд	 <p>Уурхайн технологийн замын тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайд шүүрлийн ус гараагүй байгаа тул замын усалгаа, тоосжилт бууруулахад борооны усыг хуримтлуулан усан сан байгуулан ашиглаж байна.</p>	MNS 4943:2015
Тээврийн хэрэгсэлд оношилгоо засвар үйлчилгээг тогтмол хийж хийн ялгаралд хяналт тавих	Уурхайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд	Тээврийн хэрэгсэлд оношилгоо засвар үйлчилгээг цаг тухай бүрт нь улсын үзлэг оношилогоонд тогтмол хамруулсан. Мөн техник тус бүрийн янданд угаар шүүгч суурилуулж ажиллаж байна.	Хүнд даацын авто тээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 6278:2012

4.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 10. Хөрсөн бүрхэвчинд нөлөөллийг бууруулах

Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал /мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Ажлын гүйцэтгэл	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
Олон салаа зам гарган хөрс эвдрэхээс урьдчилан сэргийлэх, маршрутын зам ашиглах тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Уурхайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд	Тухай бүр	 <p>Олон салаа зам гарган хөрс эвдрэхээс урьдчилан сэргийлж маршрутын зам ашиглах MNS 4597 : 2014 ийн дагуу тэмдэг тэмдэглэгээг байршуулсан</p>	Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597 : 2014
Хөрсний бохирдлын болон эрүүл ахуйн мониторинг тогтмол хийлгэж, хөрс хамгаалах, цэвэрлэх бодис, технологиудыг нэвтрүүлэх	Уурхайн суурьшлын бүс	Үйл ажиллагааны зардалд	2022 онд	Ажилчдын хотхон, бие засах газар, бохирын цооног орчмын 4900м ² талбайг 14 хоногт ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис ашиглан цэвэрлэгээ хийж хөрс орчны бохирдлоос хамгаалдаг.	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон

Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал /мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Ажлын гүйцэтгэл	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
Уурхайн ажилчид, суурин дахь захиргаа үйлчилгээний ажиллагсдын зорчих явган хүний замын хажуугаар зүлэгжүүлэх	Ажилчдын амрах байр орчимд	Үйл ажиллагааны зардалд	2022 онд	Ажилчдын хотхонд явган хүний замын хажуу талбайг 2022оны 6-р сард үйл ажиллагаа эхлээгүй байсан тул хаврын тохижилт хийгдээгүй байсан. 2022 оны 9 р сарын сүүлчээр хийх намарын тариалалтанд оруулж зүлэгжүүлэх ажил хийгдсэн. Энэ ажлын хүрээнд ширэг, хөмүүлийн үр, ерхөг, согооворын үр цацаж усалгаа хийсэн.	байгууламжийн ойртох зай, хэмжээ MNS 59x73 : 2009
Нийт			500		


4.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ


Хүснэгт 11. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Ажлын гүйцэтгэл	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
Уурхайн хэмжээнд ундны усны хэрэглээг багасгах, Уурхайн шүүрлийн усыг зайлуулах суваг, хуримтлуулах сан байгуулах, байнгын хяналт тавих, Тус байгуулсан усан сангаас уурхайн замын усалгаанд ашиглах	Ордын нутаг дэвсгэрт	Үйл ажиллагааны зардал	2022 онд	Одоогоор уурхайгаас шүүрлийн ус гараагүй тул борооны усыг хуримтлуулан усан сан байгуулсан. Сангийн усыг уурхайн замын усалгаанд ашиглаж байна.	
Хогийн цэгүүд дээр үерийн хаалт хийсэн бөгөөд үргэлжлүүлэн хаалт даланг сэргээн засварлаж ажиллах, хүрээлэн буй орчинд нийлүүлэх хаягдал стандартад нийцэж буй эсэхэд байнгын хяналт тавьж ажиллах	Уурхайн бүс	Үйл ажиллагааны зардал	2022 онд	Хогийн цэг дээр үер усны хаалт далан хийсэн. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх хаягдал стандартад нийцэж буй эсэхэд байнгын хяналт тавьж ажилладаг. Химийн хортой хог хаягдал баттерей, принтерийн хор зэргийг тусад нь ангилан ялгаж түр хадгалах цэгт хадгалж байна.	MNS 4943:2015 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 1

4.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ



Хүснэгт 12. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Ажлын гүйцэтгэл	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
<p>Овоолго үүсгэх талбайн үржил шимт хөрсийг хуулан шимт хөрсний агуулах талбайд хураах. Уг үржил шимт хөрсний агуулахыг 2 жилээс дээш хадгалахдаа ургамалжуулж хадгалах</p>	<p>Уурхайн бүс</p>	<p>Үйл ажиллагааны зардалд</p>	<p>2022 онд</p>	 <p>2022 онд уурхайн тэлэлт шинээр хийгдээгүй тул шимт хөрс хуулаагүй. Уг үржил шимт хөрсний чанарыг алдагдуулахгүйгээр шимт хөрсний агуулахыг ургамалжуулж хадгалах ажлын хүрээнд ЭМ биотехнологийг ашиглан шимт хөрсний овоолгыг усалж, олон наст нутгийн ургамлын үр цацаж 2023 онд ургамалжуулах арга хэмжээнд бэлтгэсэн.</p>	<p>(MNS 5916 : 2008)</p>

<p>Хавар намрын хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс сэргийлэх сургалт зааварчилгаагаар хангах</p>	<p>Уурхайн ажилчдад</p>	<p>Үйл ажиллагааны зардалд</p>	<p>2022 онд</p>	<p>Хавар намрын хуурайшилт ихтэй үед хээрийн түймэр, хаягдалын овоолгоос үүсэж болзошгүй тул гал алдахаас сэргийлж хөмсөг далан засав. (Гал түймрээс хамгаалах зурвас хөмсөг татсан байдал)</p>  <p>Хавар намрын хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс сэргийлэх сургалт зааварчилгаагаар хангах ажлыг 2022 оны 10 сард нийт уурхайн ажилчиддаа сургалт явуулсан</p>	<p>Галын аюулгүй ажиллагаа</p>
<p>Ургамлан бүрхэвч тоосонд дарагдахаас сэргийлж тээврийн замыг тогтмол усалгаа хийж замыг чийгтэй байлгах</p>	<p>Уурхайн хэмжээнд</p>	<p>Үйл ажиллагааны зардалд</p>	<p>2022 онд</p>	<p>Зам талбайн тоосжилт дарах шүүрлийн ус гараагүй. Мөн ажилласан хугацаандаа уурхайн цэвэрлэгээний ажил хийгдсэн тул зам талбай тоосжилт үүгээгүй.</p>	

4.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 13. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Ажлын гүйцэтгэл
Мал амьтан бэртэх, унахаас сэргийлж олборлолт явуулж байгаа талбайг тойруулан хаалга, хашаа татах	Олборлолт явуулж буй талбай	Үйл ажиллагааны хүрээнд	2022 онд	 <p>Төслийн талбайд мал, болон зэрлэг амьтан орох унахаас сэргийлэж хоосон чулуулаг, хаягдлыг ашиглан түр хамгаалалтын уурхайн далан, хаалгыг сэргээн засварласан.</p>
Орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөлөл, байгаль орчны албаны ажилтантай хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд тэдгээрт туслалцаа үзүүлэх,	Сүхбаатар сумын нутаг дэвсгэр	Үйл ажиллагааны хүрээнд	Тухай бүр	 <p>Орон нутгийн захиргаа иргэдийн төлөөлөлтэй байнга хамтран ажилладаг. Сүхбаатар сумын ЗДТГ-с зохион байгуулсан Мод</p>

				<p>хөтөлбөрийг дэмжиж 1 тонн дизель түлш манай компани хандивласан.</p> <p>Сүхбаатар сумын 1- р бригадад ЮНИТЕЛ- ын антен суурилуулах ажилд манай компаний ажилчид хамтран ажиллаж станцыг хугацаанд нь ашиглалтанд оруулсан.</p>
--	--	--	--	---

4.6. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа

Хүснэгт 14. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа

Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Ажлын гүйцэтгэл
Бүх ажилчдыг жилд 1 удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулах	Уурхайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2022 онд	<p>Ажилчдыг 2022 онд эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулах байсан боловч цар тахал болон мөн хил гааль, дизель түлшний хомсдол болоод уурхайн ажил бүрэн хүчин чадлаар хэвийн ажиллах боломжгүй байсан.</p> <p>Цөөн ажиллагсад 2 сарын хугацаанд бэлтгэл ажил хийсэн. 2023 оны эхний улиралд компаний зүгээс бүх ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зорилготой байна</p>
Эмнэлгийн анхны түргэн тусламжийн хайрцгийг ажилчдын байр, ажлын байр, автомашинд байрлуулах. /Байнгын шалгалт хийж хэрэглэсэн, шаардлага хангахгүй болсон хэрэгслийг солих/	Уурхайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2022 оны турш	<p>Эмнэлгийн анхны түргэн тусламжийн хайрцгийг ажилчдын байр, ажлын байр, автомашинд байрлуулсан мөн цаг тухай бүрд нь шалгалт хийж байдаг.</p>
Бүх ажилчдад улирал тутам холбогдох сургалтаар хангах	Бүх ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2022 онд	<p>Ажилчдад ХАБЭА шинчилсэн журмын дагуу сургалт заавар зааварчилгаагаар хангаж 2022 оны 10 сард “Галын аюулгүй байдал” сэдэвт сургалт зохион байгуулсан</p>

5. БАЙГАЛЬ ОРЧИН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР Хүснэгт 15.

Байгаль орчны хүчин зүйл	Хяналт үзүүлэлт	Байршил	Давтамж	Хууль, бодлого, стандарт	Ажлын гүйцэтгэл	Төсөв, мян. төг
Агаарын чанар						
Хөрс хуулах, элс, хайрга олборлох зэргээс тоос босож агаар бохирдох Машин механизмын хорт хий ялгарах	CO ₂ , NO ₂ , SO ₂ Тоос нийт (PM10, PM2.5) Дуу чимээ, шуугиан, доргио	Ил уурхайн салхины чиглэл доор-тус бүр 1 цэг Засварын талбай-1 цэг Уурхайн тосгон-1 цэг	Жилд 1 удаа	MNS 4585:2016	Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний Газар 2022-10 сард шинжилгээ хийсэн болно. Шинжилгээний хариуг хавсаргав.	3цэг*55.5 мян.төг=135.0 мян.төг
Хөрсөн бүрхэвч						
Шатах тослох материал, хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрсний механик бүтэц, хими физикийн шинж чанар, бохирдол, нефтийн бүтээгдэхүүн	Хог хаягдлын цэг-1 цэг ШТМ-ын агуулах-1 цэг	Жилд 1 удаа	MNS 5850:2008	Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид 2 цэгээс дээж авж хүргүүлсэн болно.	2цэг*40.0 мян.төг=63.0 мян.төг
Ус						
Хөрсний бохирдлоор дамжин газрын доорх ус бохирдож, уурхайн ус ашиглалтаас газрын доорх усны түвшин буурах	Усны чанарын үндсэн үзүүлэлт болон анион, катион, хүнд металл	Уурхайн 1 худаг -1 цэг Уурхайн шүүрлийн уснаас – 1 цэг	Жилд 1 удаа	MNS 900:2005 MNS 4943:2015	Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний Газар 2022-10 сард шинжилгээ хийлгэсэн болно. Шинжилгээний хариуг хавсаргав.	2цэг*42.0 мян.төг=50.0 мян.төг
Цацрагийн судалгаа						
Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр цацраг идэвхт бодист агаар мандалд дэгдэх	Цөмийн энергийн газрын лабораторид Гамма спектрометрийн шинжилгээ хийлгэх	Хөрсний овоолго Олборлолтын талбай Нүүрс ачих буулгах талбай	Жилд 2 удаа	MNS 5072:2001	Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний Газар 2022-10 сард шинжилгээ хийсэн болно.	3цэг*35.0 мян.төг=105.0 мян.төг*2удаа= 85.0 мян.төг

					Шинжилгээний хариуг хавсаргав.	
Нийт дүн						610.5

6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 16. Хог, хаягдал

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Ажлын гүйцэтгэл
Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах Хог хаягдлыг дахин ялгах	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	500.0	2022 он	Хог хаягдал ангилан ялгах сав бэлтгэж тосгон, захиргаа, цайны газар зэрэг газруудад тус бүр нэг сав буюу нийт 3 байршилд байрлуулсан. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгасны дараа дахин ашиглагдах болон ашиглагдахгүй 2 төрлөөр ангилан ялгаж хогийн түр цэгт хаяж байна.
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байх	Уурхайн төлөвлөлтөөр		
Хог хаягдлаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	1,000.0	2022 он	Уурхайн үйлчилгээний машин техникийн засвар хийх граж, тос тосолгоо хийх цэгтэй болсон.
Шингэн хаягдал	Хаягдал бохир усыг “Ирвэс Интэртрейд” ХХК-ийн худалдаалж буй “Тамир-Эм” био бэлдмэлээр сар тутам ариутгаж ажилчдын бие засах газар луу зайлуулах	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Тухай бүрд	Ажилчдын суурингаас гарч байгаа шингэн хаягдлыг Тамир-Эм био бэлдмэлээр сар тутамд ариутгаж байна. Мөн ажилчдын бие засах газрыг энэхүү бэлдмэлээр ариутгадаг.
Төслийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаар хөрс, гадаргын болон газрын доорх ус бохирдуулах сөрөг нөлөөтэй	Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж хуримтлуулах, боломжтой бол хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Тухай бүрд	Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж хоёрдогч түүхий эд авах цэгт хүлээлгэн өгнө.
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах		Тухай бүрд	Хөрс шатах тослох материалаар тухайн бохирдсон хэсгийг авч саармагжуулахад ЭМ био бэлдмэлийг хэрэглэн ариутгадаг.

Ахуйн аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Хэрэглэсэн батарей, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Тухай бүрд	Хэрэглэсэн баттерей, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг кемпийн агуулахад битүүмжлэн хадгалж байна.
